

# ИРГЭДЭЭС ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН САНАЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ



2025 оны 01 дүгээр  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

## Нэг. Иргэдээс цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар


Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын удирдах албан тушаалтанд 2024 онд иргэдээс 21633 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2667 нэгжээр буюу 10.9 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 341 буюу 1.6 хувь нь санал, 20915 буюу 96.7 хувь нь өргөдөл, 377 буюу 1.7 хувь нь гомдол байна.



Санал, өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 1311 буюу 6.1 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 384 буюу 1.8 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 2801 буюу 12.9 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 4549 буюу 21.0 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 860 буюу 4.0 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 11728 буюу 54.2 хувь нь бусад / Хувийн хэргээс баримт бичиг, дипломын хавсралт авах, мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой/ өргөдөл, гомдол байна.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 21476 буюу 99.3 хувийг шийдвэрлэж, 157 буюу 0.7 хувь нь ажиллагаанд байна.



**Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар**


2024 онд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, алба хаагчдаас 890 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 203 нэгжээр буюу 29.5 хувиар өсчээ.


Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 792 буюу 88.9 хувь нь өргөдөл, 94 буюу 10.6 хувь нь гомдол, 4 буюу 0.4 хувь нь санал байна.



**Иргэдээс цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг үтгээр нь авч үзвэл:**

66 буюу 7.4 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 64 буюу 7.2 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 91 буюу 10.2 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 20 буюу 2.2 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 127 буюу 14.3 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 522 буюу 58.7 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.






**Гурав. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирсэн санал хүсэлт, гомдол, шүүмжлэлийн талаар**

2024 онд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 6040 санал, өргөдөл, гомдол, талархал, ирүүлсний 358 буюу 5.9 хувь нь санал, 4243 буюу 70.2 хувь нь гомдол, 593 буюу 9.8 хувь өргөдөл, 846 буюу 14.1 хувь нь талархал байна.


Нийт санал хүсэлт, өргөдөл, гомдол, талархлын 311 буюу 5.1 хувь нь цагдаагийн алба хаагчийн ёс зүй зөрчсөн, 1277 буюу 21.1 хувь нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, 554 буюу 9.1 хувь нь зөрчлийн шинжтэй, 557 буюу 9.2 хувь нь мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой, 548 буюу 9.1 хувь нь тээврийн хэрэгслийн торгуультай холбоотой, 2793 буюу 46.2 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэлийн 5527 буюу 91.5 хувийг шийдвэрлэж, 513 буюу 8.5 хувийг холбогдох алба, нэгжид судалж байна.

**Дөрөв. Иргэдээс цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар**

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчтай холбоотой ирүүлсэн нийт 2444 өргөдөл, гомдолд 2811 алба хаагчийг холбогдуулан шалгажээ. Үүний 2507 буюу 89.2 хувийг офицер, 298 буюу 10.6 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.



Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 121 буюу 5.0 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 560 буюу 22.9 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 88 буюу 3.6 хувь нь хэргийн хугацаа хэтрүүлсэн, 90 буюу 3.7 хувь нь бусдыг чирэгдүүлж, танил тал харсан, 13 буюу 0.5 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 463 буюу 18.9 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 58 буюу 2.4 хувь нь бусдын эрх чөлөөнд халдсан, 402 буюу 16.4 хувь нь ажлын хариуцлага алдсан, 26 буюу 1.1 хувь нь архидан согтуурсан, 5 буюу 0.2 хувь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 449 буюу 18.4 хувь нь Эрүүгийн хэрэг хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн, 6 буюу 0.2 хувь нь цалин, тэтгэвэр тэтгэмж буруу олгосон, 163 буюу 6.7 хувь нь бусад зөрчлүүд эзэлж байна.



Нийт хүлээн авсан **2444** өргөдөл, гомдлоос **2368 буюу 96.9** хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, **76 буюу 3.1** хувьд нь хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

Шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл: Холбогдсон алба хаагчдын 37 буюу 1.3 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай холбогдох байгууллагад шилжүүлж, 299 буюу 10.6 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулж, 2245 буюу 79.9 хувьд нь цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, 9 буюу 0.3 хувьд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн үндэслэлээр хааж шийдвэрлэсэн байна.

## ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС